



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2015 оны 07 сарын 29 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

**Нэрийн дансны 2015 оны орлогод тооцох
хүүгийн хэмжээг тогтоох тухай**

Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 7 дугаар заалт, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2015 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн хурлын 04 дүгээр тэмдэглэл, Үндэсний статистикийн хорооны 2015 оны 01/320 дугаар албан тоотоор ирүүлсэн саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Даатгуулагчдын тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2015 оны орлогод тооцох жилийн хүүгийн хэмжээг 10.2 хувиар баталсугай.

Хоёр. Нийгмийн даатгалын ерөнхий газар (Ц.Уртнасан)-т ДААЛГАХ нь:

а/ Баталсан хүүгийн хэмжээг үндэслэн даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны улирал бүрийн орлогод хүү тооцох ажлыг дараа улирлын эхний сард багтаан хэрэгжүүлж ажиллах.

б/ Нэрийн дансны мэдээлэх хуудсыг даатгуулагчдад улирал бүрийн эхний сард багтаан мэдээлэх ажлыг зохион байгуулах.

Гурав. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавихыг Ажлын алба (М.Саранчимэг)-нд даалгасугай.

ДАРГА  С.ЭРДЭНЭ